

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эко Баяновоо хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2024 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533539 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533539 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

“ЭКО БАЯНОВОО ХОТ
ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Э.МЭНДСАЙХАН ТАНАА

2024.02.13 № 245
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эко баяновоо хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эко баяновоо хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,203,115.1 мянган төгрөгийн авто замыг бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 71,628.3 мянга, зардлыг 70,649.2 мянга, 881.2 мянган төгрөгийн ашигтай байхаар баталж гүйцэтгэлээр 73,009.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн 72,732.4 мянган төгрөг зарцуулж 249.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

016020437

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	782,788.80	2,019,564.94
2	Дансны авлага	4,012,534.32	1,269,202.00
3	Татвар, НДШ-ийн авлага	-	412,064.18
4	Бараа материал	-	250,000.00
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,795,323.12	3,950,831.12
6	Үндсэн хөрөнгө	188,604,389.80	3,587,833,399.52
7	Бусад үндсэн хөрөнгө	1,310,000.00	1,130,000.00
8	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	189,914,389.80	3,588,963,399.52
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	194,709,712.92	3,592,914,230.64
10	Татварын өр	1,274,247.61	-
11	Хойшлогдсон орлого	189,006,068.80	3,588,235,078.52
12	Богино хугацаат өр төлбөр	190,280,316.41	3,588,235,078.52
13	Өр төлбөрийн нийт дүн	190,280,316.41	3,588,235,078.52
14	Өмч: а) төрийн	16,000.00	16,000.00
15	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4,413,396.51	4,663,152.12
16	Эздийн өмчийн дүн	4,429,396.51	4,679,152.12
17	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	194,709,712.92	3,592,914,230.64

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	35,910,343.39	48,408,005.10
2	Борлуулалтын өртөг	38,560,489.23	59,789,826.25
3	Нийт ашиг	(2,650,145.84)	(11,381,821.15)
4	Бусад орлого	7,179,092.00	24,601,903.52
5	Ерөнхий ба удирдлагын зардал	13,326,604.27	12,942,576.14
6	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,797,658.11)	277,506.23
7	Орлогын татварын зардал	-	27,750.62
8	Татвар дараах ашиг (алдагдал)	(8,797,658.11)	249,755.61
9	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,797,658.11)	249,755.61

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	16,000.00	13,211,054.28	16,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	16,000.00	13,211,054.28	13,227,054.28
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	(8,797,657.77)	(8,797,657.77)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	16,000.00	4,413,396.51	4,429,396.51
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	16,000.00	4,413,396.51	4,429,396.51
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	249,755.61	249,755.61
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	16,000.00	4,663,152.12	4,679,152.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	51,055,141.10	52,409,144.89
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	51,055,141.10	52,409,144.89
4	Мөнгөн зарлагын дүн (-)	54,004,176.96	51,172,368.75
5	Ажиллагчдад төлсөн	22,045,907.00	21,033,572.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,806,543.96	6,839,549.30
7	Бараа материалын худалдан авахад төлсөн	13,602,500.00	15,205,451.69
8	Ашиглалтын зардалд төлсөн	1,597,485.03	-
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,740,420.00	-
10	Татварын байгууллагад төлсөн	5,756,195.97	7,866,395.76
11	Бусад мөнгөн зарлага	455,125.00	227,400.00
12	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,949,035.86)	1,236,776.14
13	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,949,035.86)	1,236,776.14
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,731,824.66	782,788.80
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	782,788.80	2,019,564.94

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 908.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 412.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 496.9 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг ангилал буруу бүртгэсэн нь НББОУС 1 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 412.0 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар нийт 16.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 16.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг шалгахад төлбөрийн баримтгүй 496.9 мянган төгрөгийн 3 ажил гүйлгээ байна.	1	496.9	-	-	-	-	-	-	1	496.9	1	496.9
Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг авлагыг ангилал буруу бүртгэсэн байна.	1	412.0	-	-	1	412.0	1	412.0	-	-	-	-
Дүн	2	908.9	-	-	1	412.0	1	412.0	1	496.9	1	496.9

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангаар эздийн өмчийн дүн 16.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	16.0	-	-	-	-	1	16.0	-	-	-	-
Дүн	1	16.0	-	-	-	-	1	16.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил² илэрснээс шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах талаар 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тус байгууллага нь тайлант хугацаанд байгуулсан гэрээт ажил, үйлчилгээний гэрээг дүгнэж, ажлын гүйцэтгэлийг үнэлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.